

## Тайшир сумын ЗДТГ-аас хэрэглэгчийн эрхийг хамгаалах сарын аян зарлав.

Тайшир сумын ЗДТГ-аас 2018 оны 04 сарын 26-наас 05 дугаар сарын 25-ний өдрийг хүртэл 1 сарын хугацаанд “Хэрэглэгчийн сэтгэлд нийцсэн үйлчилгээ” сэдэвт сарын аяныг зарлаж, нээлтийн ажиллагааг зохион байгуулав.



Нээлтийн ёслолыг Засаг даргын орлогч Г.Баасанжав нээж, Улсын тэргүүний ардын авьяастан С.Баянмөнх уртын дуугаар ая дууны мэндчилгээ өргөлөө. Мөн ИТХ-ын дарга Л.Ганхуяг үг хэлж, хэрэглэгчийн эрхийг хамгаалах талаар ААНБ-дад үүрэг өглөө.



Засаг даргын Тамгын газрын дарга Г.Болормаа Хэрэглэгчийн эрхийг хамгаалах орон тооны бус салбар зөвлөлийг байгуулсан сумын ИТХ-ын тогтоол, сарын аяны хүрээнд хийх ажлын төлөвлөгөөг танилцуулав.



Дотоод ажил хариуцсан мэргэжилтэн Ч.Оюунгэрэл “Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай” хуулийн танилцуулга хийж, иргэдэд гарын авлага тараалаа.



Тус сумд үйл ажиллагаа явуулдаг төрийн болон хувийн хэвшлийн 20 орчим байгууллага, ААН-ийн дарга удирдлагууд өөрийн бүтээгдэхүүн үйлчилгээ, хэрэглэгчдэд үзүүлэх хөнгөлөлт урамшууллын талаар танилцуулж, сарын аяны хүрээнд хэрэглэгчийн таашаалд нийцсэн ямар үйлчилгээ үзүүлэх талаар үүрэг амлалт авлаа.

- **ИТХ, ЗДТГ:** Хууль тогтоомжийн сургалт сурталчилгааны ажлыг сайжруулах, Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах орон тооны бус зөвлөлөөс үйлчилгээний байгууллагуудад хийх хяналт шалгалтыг тогтмолжуулах, ЗДТГ-ын ажиллагсад төрийн үйлчилгээг хэрхэн хүргэж байгаад хяналт тавих зорилгоор үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг үнэлэх самбар байршуулж, иргэдээс өдөр тутам үнэлгээ авах ажлыг эхлүүлсэн.  
Сумын төвд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, Халуун усны шүршүүрийг шинэчлэх, цэвэрлэгээ үйлчилгээний чанарыг сайжруулах, Ундны усны худгийн байранд засвар, ариутгал, цэвэрлэгээ хийх зэрэг нийтийн эзэмшлийн байгууламжуудын засвар тохижилтын ажлуудыг хийхээр амласан байна.
- **Сургууль:** Хичээлээ байнгын нээлттэй болгож, эцэг эхчүүдийг хичээлд урьж суулгах, багш сурагчдын хооронд итгэлцлийн үнэлгээ бий болгох, анги дэвших, сургууль төгсөх шалгалтанд бэлтгэх давтлагын тоог нэмэгдүүлэхээр төлөвлөжээ.
- **Соёлын төв:** Үзэгчдэд зориулсан хувцасны өлгүүр, малгайны тавиур хийх, Залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх биллиардны ширээтэй болох, Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгаа авах хайрцаг хийж байрлуулахаар болсон байна.



- **Цэцэрлэг:** Хүүхдийн хоолны амталгааг эцэг эхчүүдээр хийлгэж үнэлгээ авах, Оюунлаг тоглоомын танхимтай болж, багш нар гарын доорх материал ашиглан тоглоом хийх юм байна.
- **Хаан банк:** Хадгаламжийн урамшуулалт аян зарласан. Сарын аяны хугацаанд зээлийн өргөдлийн хураамжийг тэглэхээр болсон байна. Мөн мобикомын нэгжийг салбар тооцооны төвөөс болон цахим банкаар шууд худалдан авах боломжтой болсон.



- **Төрийн банк:** Тооцооны төвийн байрандаа засвар үйлчилгээ хийж, иргэдийг ая тухтай үйлчлүүлэх боломж бүрдүүлэх, цахим банк бүтээгдэхүүн үйлчилгээнийхээ талаар хэрэглэгчдэд сургалт зохион байгуулахаар болжээ.



- **Холбоо:** Интернэтийн хурд 2 дахин нэмэгдэж, айл өрхийн холболтын болон суурь хураамжинд хаврын 10%-ийн урамшуулал зарлав.



- **“Алтай-Улиастай эрчим хүч” ТӨҮГ-ийн харьяа Тайшир дэд станц:** Хэрэглэгчдэд цахилгааны утасны сонголт, хэрэглээний талаар зөвлөмж өгч, айл өрхийн цахилгааны утас, монтажны засвар үйлчилгээг сарын хугацаанд үнэ төлбөргүй хийж өгөхөөр боллоо.



- **Гэгээн нуур ОНӨААТҮГ:** Тайшир сумын иргэдийг цэвэр усаар тасралтгүй хангах, ЗДТГазраас зохион байгуулж байгаа сургалт зөвлөгөөний үеэр цэвэр усаар үнэгүй хангахаар амласан.



- **Хөх толгой ХХК-ний “Эх наран” дэлгүүр:** Е-Баримтаа тогтмол өгөх, хүүхдийн баяраар бараа бүтээгдэхүүний үнийн хөнгөлөлт үзүүлнэ. Хүнсний талоны бүтээгдэхүүнийг санхүүжилтээс шалтгаалахгүйгээр урьдчилан олгож байхаар болсон.



- **Мобиком ХХК:** Аймгийн салбараас ирж, Тайшир сумын иргэдэд үйлчилгээ үзүүлсэн. “Stars” үйлчилгээнийхээ шинэ дугаарыг 1000 төгрөгөөр худалдан авч, 18 нас хүртэл аав ээжтэйгээ үнэгүй ярих урамшуулал зарлажээ. Мобикомын сүлжээний антенийг улаан боомын усан цахилгаан станцын орчмоос Тайшир сумын төвд нүүлгэн шилжүүлхээр төлөвлөж байгаа.

- **Юнителийн гэрээт борлуулагч:** Сумд 05 сарын 16-аас 06 сарын 16-нийг хүртэл хямдралтай, урамшуулалтай худалдаа зарлана.
- **Зост-Өндөр ХХК:** Газар доорх дулааны шугам сүлжээний байршлын схем гаргаж байгууллагуудад хүргүүлэх, халаалтын шугамын засвар үйлчилгээг хугацаанд нь бүрэн хийх



- **Эрүүл мэндийн төв:** Лабораторийн тоног төхөөрөмжийг суурилуулж, цус, шээсний шинжилгээг сумд хийдэг болох, дотоодоо ажил мэргэжлийн уралдаан зохион байгуулж, мэргэжилтнүүдээ чадавхжуулах, Гадна дотор орчны тохижилт хийж, ая тухтай үйлчлүүлэх боломж бүрдүүлнэ.
- **“Даян-Алтай” ХХК:** “Болор” хүнсний дэлгүүр нь Эрүүл аюулгүй хүнс иргэдэд нийлүүлнэ. Е-баримтаа өгч хэвшинэ гэжээ.